

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2019.07.01

Арвайхээр сум

НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 11 дүгээр хуралдаан, мөн Тэргүүлэгчдийн хуралдааныг 1 удаа хийж, Төлөөлөгчдийн хуралдаанаар “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам батлах тухай”, “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах тухай”, “Түрээсийн орон сууцны тухай”, “Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг шинэчлэн батлах тухай”, “Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэл батлах”, “2019 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” асуудлуудыг хэлэлцэж, тогтоолоор шийдвэрлэв.

ИТХТэргүүлэгчдийн хуралдаанаар “Арвайхээр хотын хүнс барааны худалдааны төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай 2018 оны 31\07-02 тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт”, “Онги ус суваг” ОНӨХХК-д тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт болон 2018 оны үйл ажиллагааны тайлангийн тухай, “Төрийн дээд шагналд уламжлах тухай”, “Хөрөнгө шийдвэрлэх тухай”, “Баруунбаян-улаан сумын Эрүүл мэндийн төвийг тус сумын уугуул Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Хүний гавъяат эмч Гончигсэнгээгийн Нямхүүгийн нэрэмжит болгох тухай” зэрэг асуудлуудыг хэлэлцэж, 3 тогтоол гаргав.

Төр захиргаа, хөдөө аж ахуй, газар тариалан, хууль сахиулах, батлан хамгаалах, биеийн тамир спорт, эрүүл мэнд, боловсрол, санхүү, авто тээвэр, авто зам, байгаль орчин, төрийн үйлчилгээний салбарт олон жил ажиллаж хариуцсан ажилдаа амжилт гарган аймаг орны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан 74 иргэнийг Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүллээ.

ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хужирт, Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. Чиг үүргийн дагуу ажилтан бүр хариуцсан ажлынхаа чиглэлээр заавар зөвлөгөө өгч, санал солилцлоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Орон нутгаас сонгогдон гарсан УИХ-ын гишүүн, ХНХ-ын сайд С.Чинзориг, УИХ-ийн гишүүн, МАН-ын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, УИХ-ын гишүүн Я.Содбаатар нар тойрогтоо ажиллаж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг аймгийн хэмжээнд иргэдэд танилцуулан тэдний саналыг сонслоо.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоолын дагуу “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” зохион байгуулагдаж, үзлэгт аймгийн ИТХурал, ЗДТГазар, аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Орон нутгийн өмчийн газар, Хархорин, Хужирт сумын ЗДТГ-ыг хуваарийн дагуу хамрууллаа. Улсын үзлэгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Үндэсний Статистикийн хорооны Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Ш.Оюунгэрэл, Архивын Ерөнхий газрын

мэргэжил, арга зүйн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, улсын байцаагч Ш.Дариймаа, Архивын ерөнхий газрын Мэдээлэл, технологийн хэлтсийн мэргэжилтэн, улсын байцаагч Т.Түвшинтөгс нар шалгалтыг зохион байгуулж, нэгдсэн дүнг аймгийн удирдлагуудад танилцуулав.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуунаар ахлуулсан ажлын хэсэг Арвайхээр, Хархорин сумдад ажиллаж, Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарсан дүрэм, журмыг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах, арга зүйгээр хангах сургалтыг зохион байгуулж, төрийн захиргааны 250 гаруй албан хаагч хамрагдав. Мөн төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого төлөвлөлт, сонгон шалгаруулалт, түр томилгоо болон хууль, эрх зүйн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, арга зүйн дэмжлэгээр ханган ажиллав.

Манай аймаг элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр улсад дахин тэргүүлж, 2017 онд 528.1 хэмжээст оноо, 2018 онд улсад гуравт жагссан бөгөөд энэ жил улсын хэмжээнд 12 дугаар ангийг 16 мянган сурагч төгссөний 872 нь аймгийн 29 сургуулийн төгсөгчид бөгөөд ЭЕШ-аа шууд засалтын шилэн технологийг ашиглаж өгсөн анхны сурагчид боллоо. Үүнд Хужирт сумын ЕБС-ийн сурагч Т.Болормаа, Т.Цэцэгмаа нар Монгол хэлний хичээлээр, Хархорин сумын ЕБ-ын Гүнзгий сургуулийн сурагч О.Жадамба математикийн хичээлээр, Мэргэд сургуулийн сурагч Т.Гийхнаран, Ш.Ичинхорлоо, Б.Нандин-Эрдэнэ нар нийгмийн тухай мэдлэг хичээлээр тус тус амжилт гарган шалгалтын дээд оноо буюу 800 оноо авсан байна.

Бат-Өлзий сумын Орхон голын Онгоцтойн аманд төмөр бетонон гүүрийг шинээр барих ажлыг эхлүүлэв. Уг гүүр нь хангайн бүсийн аялал жуулчлалын бүст байрлах ачаалал ихтэй уг гүүрний урт нь 220 метр урт бөгөөд гүүрийг улсын төсвийн хөрөнгөөр барина. Мөн гүүрнээс сумын төв хүртэл 6,32 км хайрган зам, Цагаан голын 30,6 метр урттай төмөр бетон гүүрийн ажлыг хамт гүйцэтгэнэ. Шинэ гүүрийг бүрэн ашиглалтад ортол хуучин гүүрийг засварлаж ашиглалтад оруулаад байна.

Уянга суманд 400 хүний суудалтай шинэ соёлын төв ашиглалтад оруулав. Мөн тус сумын Жаргалант багийн шинэ сургуулийг ашиглалтад хүлээн авч, орон нутагт боловсролын салбарын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд, багачууд тав тухтай орчинд сурч, хөгжих орчин нөхцлийг бүрдүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны а/367 дугаар захирамжаар Арвайхээр сумын Цэцэрлэг, бага сургуулийн цогцолборын бүтэц, хэв шинжийг өөрчлөн ерөнхий боловсролын "Тэмүүлэл" сургуулийг байгуулахаар шийдвэрлэлээ. Тус сургууль нь гадаад хэл, математикийн гүнзгийрүүлсэн болон урлагийн төрөлжсөн сургалттай хичээллэх бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд 1-5 дугаар ангид, 2020 оны 1 дүгээр сараас дунд, ахлах ангидаа элсэлт авч ажиллахаар төлөвлөөд байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын хэсэг манай аймагт ажиллаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигийн хэрэгжилт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заалтыг орон нутагт газар дээр нь шалган танилцах, үнэлэлт, дүгнэлт өгөх, арга зүйн сургалт зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллав.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас "Түрээсийн орон сууцны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх тухай тогтоолын төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэв. Тус хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд 40 айлын орон сууцыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр барьж, ашиглалтад оруулахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар дэмжин, иргэдийн санхүүгийн чадавхиас шалтгаалан орон сууцыг шууд, зээлээр худалдан авах боломжгүй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, харж, хандах үр хүүхэдгүй ахмад настан, бүтэн өнчин хүүхэд, залуучууд, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн

нөлөөгөөр орон гэргүй болсон айл өрх, ажил амьдралын гараагаа эхэлж байгаа залуу гэр бүл, төв суурин газарт түр хугацаагаар ирж ажиллаж, суралцаж байгаа оюутан, залуусын түр амьдрах орон байр барих асуудлыг шийдвэрлэв.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг аймагт ажиллаж, Арвайхээр суманд баригдаж буй 928 хүүхдийн сургууль, 320 хүүхдийн лаборатори "Мэргэд" сургууль, 2 болон 4 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажилтай танилцан, салбарын 450 гаруй багш, ажиллагчдын төлөөлөл уулзалт зохион байгууллаа.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан олон хүүхэд төрүүлж өсгөсөн ээжүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Алдарт эх-I" одонгоор 15, "Алдарт эх-II" одонгоор 326 ээжийн энгэр мялааж, хүндэтгэлийн арга хэмжээг нэгдсэн журмаар олгов.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ

Улс, орон нутгийн төсвийн 43 байгууллагын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг ханган төлбөр тооцоог гүйцэтгэв. Энэ оны 6 дугаар сарын байдлаар 9523 ш төлбөрийн хүсэлтээр 44,061,9 сая төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 8 529.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 100% бүрэн орж ирсэнийг сарчилсан хуваарийн дагуу төсөвт байгууллагуудад хуваарилан санхүүжүүлэв. Тусгай зориулалтын шилжүүлэгээр 25860,2 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1997,2 сая төгрөг хуваарилагдсаныг сарчилсан хуваарийн дагуу аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилсан.

Татвар төлөлт

Энэ оны хагас жилийн байдлаар улсын төсөвт 2250.0 сая төгрөг, аймгийн төсөвт 3486.0 сая төгрөг, сумын төсөвт 1779.7 сая төгрөг, нийт 7516.7 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

Татварын удирдлагын нэгдсэн систем хэрэгжиж нэхэмжлэхэд суурилсан төлбөрийн даалгаварын дагуу 120 нэхэмжлэхийн код олгоод байна. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 7 хоногоор ээлжлэн байцаагч нар үйлчилгээ үзүүлэн 305 иргэд үйлчилгээ үзүүлэн ажилсан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын 50.0 сая төгрөг хожсон 1 иргэн, 5,0 сая төгрөг хожсон 1 иргэн 1,0 сая төгрөг хожсон 3 иргэний материал хүлээн авч ТЕГ-т хүргүүлэв. Жижиг дунд үйлдвэр эрхлэгч 21 иргэнд гэрчилгээ олгон ажилласан.

Татварын Ерөнхий Газрын даргын 2019 оны Н/40 дүгээр тушаалаар баталсан оны эхний хагас жилийн "Татварын хяналт шалгалтанд хамруулах эрсдэл бүхий татвар төлөгчийн жагсаалт"-ын дагуу татварын хяналт шалгалт хийх графикийг гарган хэлтсийн даргаар батлуулж төлөвлөгөөтөөр 8, төлөвлөгөөт бусаар 23 ААН-ийг шалгаж, нийт 203727.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн, 36697.3 мянган төгрөгийн нөхөн татвар торгууль алдангийн акт шийдвэр гарав.

Нийгмийн даатгал

Оны эхний 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийгмийн даатгалын сангуудын орлого 1901,5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 1844,4 сая төгрөг төвлөрүүлж сангийн төлөвлөгөө 96,9 хувийн биелэлттэй байна.

Энэ сард шинээр 23 ажил олгогчийн 128 даатгуулагч шинээр албан журмын даатгалд хамрагдлаа.

Мөн 910 ажил олгогчийн 12378 даатгуулагч, 7918 даатгуулагч сайн дурын албан даатгалд хамрагдав.

Энэ оны 6 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр аймгийн хэмжээнд нийт 1846 даатгуулагчдад тэтгэмжийн сангаас 1298,1 сая төгрөгийн тэтгэмж олгов. Үүнд: ХЧТА 748 даатгуулагчдад 72,2 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж-737 даатгуулагчдад 810,0 сая төгрөг, оршуулга 228 даатгуулагчдад 228,0 сая төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмж 133 даатгуулагчдад 187,9 сая төгрөг тус тус олгосон.

Хэрэглэгчийг үнэлэх үнэлгээний төхөөрөмжөөр энэ сард 19 байцаагч 7466 иргэд даатгуулагчаас үнэлгээ авсан. Үнэлгээгээр онц үнэлгээ 1877, сайн үнэлгээ 167, дунд үнэлгээ 48, муу үнэлгээ 30 даатгуулагч үнэлгээ өгөөгүй 5297 даатгуулагч байна.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх чиглэлээр аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба, Татварын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Статистикийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Зооноз өвчин судлалын төв, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв зэрэг агентлагууд, Баян-Өндөр, Сант, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан сумдад ажиллаж байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар “Архидалтгүй нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж, байгууллага”, “Камержуулалт-1” аянуудын хэрэгжих хугацаа дууссантай холбогдуулан тус аянуудын хэрэгжилт, үр дүнг хэлэлцүүлээ. Тус хурлаар уг аянуудын хэрэгжилт, үр дүнг сайшаан дүгнэж цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тогтлоо.

Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар 1 албан тушаалтны холбогдох баримтуудыг бүрдүүлэн Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлт авлаа.

Төрийн албаны зөвлөлийн шалгалт болон Архивын улсын үзлэгтэй холбогдуулан нийтийн албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлгийн баталгааны маягтын 24, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан дүгнэлтийн 6 хуулбарыг тус тус олгосон.

Архивын тасаг

Аймгийн архивын тасагт байгууллага, иргэдээс 770 өргөдөл хүлээн авч 368 лавлагаа, 1237 хуулбар, 141 тодорхойлолт олгоод байна.

“Архивын тоо бүртгэл, эрэл хайлтын программ”-д 479 хадгаламжийн нэгжийн 42862 хуудас, 25268 заалт, 226768 хүний нэр, 34693 байгууллагын нэр 41340 газар зүйн нэр бүхий захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Мөн 420 хадгаламжийн нэгжийн 45927 хуудас баримтыг PDF файл үүсгэн цахим холболтыг хийн, 435 хадгаламжийн нэгжийн 32047 хуудас баримтыг скайнердаж программд оруулсан байна.

Төрийн архивт баримт хүлээн авах хуваарийн дагуу нийт 13 байгууллагын 1963-2013 оны 1535 хадгаламжийн нэгжийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авсан.

Улсын үзлэгийн хүрээнд Боловсролын салбарын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад болон сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын удирдлагууд, архив бичиг хэргийн ажилтнуудад 3 удаагийн сургалт

зохион байгуулж, нийт 260 гаруй хүн хамрагдсан бөгөөд 46 байгууллагын ажилтнуудад мэргэжил арга зүйн зааварчилгаа, зөвлөмж өгч, ном гарын авлагаар хангав.

Мөн аймгийн Салбар комиссоос үзлэгт хамрагдах байгууллагуудын жагсаалт, урьдчилсан үзлэг явуулах хуваарийг баталж, аймгийн хэмжээнд урьдчилсан үзлэг зохион байгуулж, 12 сум, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн нийт 128 байгууллага хамрагдан, дүгнэх үзүүлэлт аргачлалын дагуу дүгнэлээ.

Улсын үзлэг явуулах төв комиссын бүрэлдэхүүн Хархорин, Хужирт сумд, аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Орон нутгийн өмчийн газар (хэсэгчилэн) Хархорин, Арвайхээр сумдын ерөнхий боловсролын сургууль, Хужирт сумын цэцэрлэг зэрэг байгууллагуудад үзлэг явуулж 95.5 хувьтай дүгнэгдсэн.

ЦАГДААГИЙН ГАЗАР

Цагдаагийн газарт оны эхний 6 сард 2321 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь 829 буюу +55.5 хувиар өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 495, зөрчлийн шинжтэй 1826 гомдол мэдээлэл бүртгэгдэн шалгаж байна.

Нийт бүртгэгдсэн Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 422 буюу 85.2 хувийг 5 хоногт, 61 буюу 12,3 хувийг 6-аас дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 1538 буюу 84.2 хувийг 3 хоногт, 259 буюу 14.2 хувийг 4-өөс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 41 нь буюу 1.7 хувийг шийдвэрлээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 06 сард 221 холбогдогчтой, 981.3 сая төгрөгийн хохиролтой, 329 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 43 хэргээр буюу +15.0 хувиар өссөн, хэргийн илрүүлэлт 31.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -10.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хэргийн төрлөөр: - Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг 10 бүртгэгдэж, 5 буюу +2.0 дахин, - Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 23 бүртгэгдэж 18-аар буюу +4.6 дахин, - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 20 бүртгэгдэж 8-аар буюу +66.6%, - Залилах гэмт хэрэг 14 бүртгэгдэж 10-аар +3.5 дахин, - Мал хулгайлах гэмт хэрэг 29 бүртгэгдэж 22 буюу +4.1 дахин, - Дээрэмдэх гэмт хэрэг 4 бүртгэгдэж, 2-оор буюу +3.0 дахин, - Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 16 бүртгэгдэж 3-аар буюу +4.0 дахин тус тус өсч,

- Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 73 бүртгэгдэж 14-өөр буюу -16.1 хувиар буурсан, - Авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 9 бүртгэгдэж 11-ээр буюу -55.0 %-иар буурч, - Тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 8 бүртгэгдэж 12-оор буюу -60.0 хувиар тус тус буурсан байна.

- Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг, Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, бүртгэгдсэн гэмт хэргийн дотор 66.1 хувийн эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 06 дугаар сарын байдлаар Өмчлөх эрхийн эсрэг 170 гэмт хэрэг бүртгэгдснээс иргэдийн өмчийг хулгайлах 82, малын хулгайлах гэмт хэрэг 32, тээврийн хэрэгсэл хулгайлах 12, дээрэмдэх 6, залилах 16 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 50 буюу +41.6 хувиар, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 19 бүртгэгдэж 11-ээр буюу +2.3 дахин тус тус өссөн байна. Үүнээс Залилах гэмт хэрэг 16 бүртгэгдэж 7-оор буюу +1.7 дахин, мал хулгайлах гэмт хэрэг 32

бүртгэгдэж 18 хэргээр буюу 2.2 дахин, иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 82 бүртгэгдэж 20 хэргээр буюу +32.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 114 бүртгэгдэж 24 хэргээр буюу -26.6 хувиар, Тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 12 бүртгэгдэж 12-оор буюу -2.0 дахин буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн дийлэнх хувийг цонх хагалах, хөших, цонхоор орох, гэр, орон сууцны хаалга, цоожийг нь эвдэж орох, гэриний тооноор орох, малын хулгайн гэмт хэрэг нь иргэдийн хараа хяналт сонор, сэрэмж сул, малаа байнга хариулага маллагагүй орхидог, цахимаар иргэдийг хууран мэхэлж, итгэл эвдэх байдлыг ашиглан үйлдэгдэж байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны 06 дугаар сард нийт бүртгэгдсэн 329 гэмт хэргээс 89 буюу 27.1 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна. Зөрчил өмнөх оноос 7974 буюу +79.1 хувиар өссөн байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажын үр дүн, олон нийтийн эргүүл, байнгын пост, цагийн менежменттэй постуудыг ажиллуулснаар тодорхой үр дүнд хүрч байгаагаар тодорхойлогдож байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

“Хэнийг ч орхигдуулахгүй байх”, Эх, хүүхдийн явуулын тусламж үйлчилгээний 2-р шатны баг сумдын эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж нийт 257 эх, хүүхэд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд үзлэг хийж зөвлөгөө өгч ажиллалаа.

ЭМХТ-ийн магадлан итгэмжлэл лицензийн албанаас ирсэн мэргэжилтнүүдийн хамт Есөнзүйл, Хайрхандулаан, Хужирт, Арвайхээр сумдад ажиллаж 7 байгууллагад магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээ хийлээ.

Хөх хотын Монгол эмнэлгийн хороотой хамтран ажиллах санамж бичгийг байгуулан эмч мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах ажлыг зохион байгууллаа. БНХАУ-ын Гуанжоу Шинжинь хотод болсон олон улсын хуралд ЭМГ-аас 2 мэргэжилтэн оролцлоо.

ГССҮТ-тэй хамтран Хайрхандулаан суманд 50, Нарийнтээл суманд 102, Баруунбаян-Улаан суманд 67 иргэнийг гэмтэл согогийн эрт илрүүлгийн үзлэгт хамруулж, иргэдэд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж 154 иргэнийг хамруулав.

НЭМҮТ-ийн судалгааны багийг хүлээн авч, Арвайхээр, Тарагт, Зүүнбаян-Улаан сумын ерөнхий боловсролын сургууль болон эрүүл мэндийн төвийг түшиглэн “Дэлхийн залуучуудын тамхины судалгаа”-нд тус бүр 5 анги, “Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох үндэсний судалгаа”-нд 18-69 насны тус бүр 80 иргэнийг хамруулав.

“Дэлхийн автомашингүй, тамхигүй өдөр”-өөр 200 орчим иргэнийг оролцуулан, ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулав.

“Залуу нас-Гэрэлт ирээдүй” төслийн хүрээнд Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгтэй хамтран нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг энэ сарын 8-9-ний өдрүүдэд Арвайхээр хотноо зохион байгууллаа. Сургалтад төр, төрийн бус байгууллагын төлөөлөл, ерөнхий боловсролын сургуулийн эмч нар, эмч бүлгийн хүүхдүүд, нийгмийн ажилтан зэрэг 30 хүн хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдсэн.

Геронтологийн үндэсний төвтэй хамтран ахмадуудад 5 төрлийн үзлэг, сургалт зохион байгуулж 250 гаруй ахмад настанг хамруулав. “Геронтологи, гериатрийн үндсэн ойлголт, орчин үеийн оношилгоо, эмчилгээний чиг хандлага” сэдэвт багц

цагийн сургалтанд эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамтарсан СОРЕ үнэлгээ хийсэн

Улаанбурхан улаануудын нэмэлт дархлаажуулалтанд хамрагдвал зохих 15944 хүүхдээс 15104 буюу 94.7%-ийг хамруулсан.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх нь” төслийн II үе шат болох “Гэрэлт ирээдүй-Залуу нас” төсөл манай аймагт хэрэгжиж эхлээд байна. Уг төслийг “Оновчтой Хөгжил” ТББ хариуцан гүйцэтгэх ба төслийн гол зорилго нь аймгийн хэмжээнд БЗДХ-ын тархалтыг бууруулахад өсвөр үеийнхэн, залуучууд болон иргэний нийгмийн хариуцлагын механизмыг бий болгоход чиглэгдэнэ. Аймгийн Эрүүл мэндийн газар мэргэжил арга зүйн зөвлөх гол хамтрагч байгууллагаар ажиллана. Төслийн хүрээнд Монголын Гэр бүл сайн сайхны нийгэмлэгтэй хамтран НҮЭМ-ийн сургагч багш бэлтгэх сургалтыг төр, төрийн бус байгууллагын төлөөлөл, ЕБС-ийн эмч, эмч бүлгийн хүүхдүүд, нийгмийн ажилтан зэрэг 30 хүн НҮЭМ-ийн сургагч багш, хүүхдээр бэлтгэгдэж сертификатаа гардан авлаа.

Монгол Улсын гавьяат багш Б.Мөнхжаргалын нэрэмжит “ТОО БОДОЖ ОЮУНАА ХӨГЖҮҮЛЬЕ” олимпиадад 29 сургуулийн 7, 11 дүгээр ангийн 102 бүлгийн 2708 сурагч, “ЭХ ХЭЛ ЭРДМИЙН ТҮЛХҮҮР” олимпиадад 29 сургуулийн 6, 9, 11-р ангийн 135 бүлгийн 3474 сурагч, “ГАДААД ХЭЛ- ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР” олимпиадад 29 сургуулийн 6, 8-р ангийн 132 бүлгийн 1954 сурагч, “ЭХ ТҮҮХЭЭ ЭРХЭМЛЭЭ” олимпиадад 26 сургуулийн 10 дугаар ангийн 53 бүлгийн 1280 сурагч 2 үе шатаар мэдлэг чадвараараа өрсөлдөж, тэргүүний анги хамт олон, сурагчдаа шалгарууллаа.

2019 оны элсэлтийн ерөнхий шалгалтыг 6-р сарын 17-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Боловсрол, соёл, урлагийн газрын даргын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах ажлын хэсэг, хянагч багш нийт 44 албан хаагчдыг томилж ажилласан. Нийт 10 шалгалтад давхардсан тоогоор 2349 шалгуулагч орохоос 2202 шалгуулагч шалгалтад хамрагдаж, нийт шалгалтын ирц 94 хувьтай байсан. Манай аймагт их, дээд сургуулиудын 2315 хяналтын тоо ирсэн бөгөөд тэдгээрээс албан ёсны жагсаалтад орж 273 элсэгч их, дээд сургуульд элсэн суралцах эрхийн бичиг гардан авсан байна.

Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд ерөнхий боловсролын тавдугаар сургууль байгуулагдаж байгаатай холбогдуулан багш, ажилтны нөөц бүрдүүлэх сул ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлаж, 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдөр сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Тус сонгон шалгаруулалтад 211 багш, ажилчид хамрагдан 103 хүн тэнцсэнээс 40 нь ажлын байраар хангагдаж 63 багш нөөцөд бүртгэгдлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/804 тоот тушаалаар “Азийн ардын урлагийн их наадам”– Улаанбаатар хотноо зохион байгуулж, Өвөрхангай аймгийн 50 гаруй биет бус өв өвлөн уламжлагч Азийн Ардын урлагийн Анхдугаар Их наадамдаа уртын дуу, морин хуур, язгуур урлаг, бий биелгээ, зан үйлийн чуулбараар амжилттай оролцоо.

Тус наадамд Малайз, БНХАУ, Япон, БНСУ, Франц, Турк, Энэтхэг, ОХУ, Буриад, Тува, Узбекстан зэрэг 20 гаруй орны 200 гаруй ардын авьяастан оролцсон Биет бус өвийн том арга хэмжээ боллоо.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

2019 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар аймгийн хэмжээнд байнгын 423, түр 108, улирлын 72 шинэ ажлын байр тус тус бий болсон байна. Нийт шинэ ажлын байрыг эдийн засгийн салбар ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 16%, боловсруулах үйлдвэрлэлд 32%, бөөний худалдаа 9% , боловсролын салбарт 12%, уул уурхайд 1%, бусад салбарт 30% тус тус байна.

Шинэ ажлын байрыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 91 буюу 22% нь төсвийн байгууллага, 332 буюу 78% нь хувийн хэвшилд бий болсон байна. Тухайн сард аймгийн хэмжээнд 334 ажил хайгч иргэний бүртгэлийг хөтөлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлээ. Ажил хайгч иргэдийн бүртгэл 1862 байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд 486, бүлгийн зөвлөгөө мэдээлэлд 413 иргэнийг тус тус хамруулж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлээ.

Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагаас 392 ажлын байрны захиалга хүлээн авч 357 иргэнийг ажлын байранд зуучиллаа.

Арвайхээр сумын 21 аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулах сургалт сурталчилгааг зохион байгуулсан. Дээрх аж ахуйн нэгж байгууллагуудаас зөрчил илрээгүй болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт 29 иргэнийг хамруулж, 63.5 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд гарааны бизнесийг дэмжих “STARTUP WEEKEND” арга хэмжээг Өвөрхангай аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, “Бэст инноваци” бизнес хөгжлийн дэмжих төвтэй хамтран амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд 14-34 насны 100 залуучууд бүртгүүлснээс 34 багийн 86 залуучууд орон нутгийн онцлогийг тодорхойлсон хөдөө аж ахуйн, хүнсний үйлдвэрлэл, гар урлал, гоо сайхан, авто засвар, хэвлэл, аялал жуучлал, барилгын материал үйлдвэрлэл, төмөр хийцийн чиглэлээр гарааны бизнесийн шинэлэг санаа, өвөрмөц шийдлээ танилцуулж оролцлоо. Шалгаруулалтанд 23 баг шалгарч тус бүр 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эрх болон бэлтгэл хурдасгуур хөтөлбөрт хамрагдах батламж гардан авлаа.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөрийн мэргэжлийн сургалтыг Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллежтой хамтран “Хоол үйлдвэрлэл, тогооч”, “Талх, нарийн боов үйлдвэрлэл”-ийн мэргэжлээр Хархорин, Хужирт сумдуудад 60 иргэнийг хамруулж 8.0 сая төгрөгийн санхүүжилт зарцуулаад байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдсан 4 ахмад настанд 1.6 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн ажил олгогчийг урамшуулах арга хэмжээнд хамрагдахаар 2018 онд гэрээ байгуулж, шаардлага хангасан 1 аж ахуйн нэгжид 3.1 сая төгрөгийн ажил олгогчийн дэмжлэгийг олголоо.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2016 онд хамрагдаж эргэн төлөлтөө дутуу хийсэн 27 иргэний төлбөрийг төлүүлэхээр Иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргаж, эвлэрлийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд аж ахуй эрхлэлтийн сургалтын бүртгэлийг зарлаж хамрагдах хүсэлтэй 150 иргэнийг бүртгэж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдэд “Дэлгэрэх бүтээмж” ТББ-тай хамтран аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж, 60 иргэнийг хамруулж, төсөл хөтөлбөрийн чиглэлээр мэдээлэл өгч ажиллаж байна.

Энэ оны 06 сард улс болон орон нутгийн төсвөөс халамжийн тэтгэвэрт 1224.6 тэрбум төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 778.9 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 515.7 сая төгрөг, ахмад настаны нийгмийн халамжийн үйлчилгээнд 377.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 118.4 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 198.2 сая төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 773.7 сая төгрөгийг тус тус зарцууллаа. Банкны шимтгэл, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллын зардалд 12.9 сая төгрөг олгосон байна. Алдар цолтон ахмад настануудын тэтгэмжид 38.0 сая төгрөг, алдарт эхийн тэтгэмжид 1350.4 тэрбум төгрөг, насны хишгийн зардалд 470.0 сая төгрөг, өрх толгойлсон эх эцгийн тэтгэмжид 89.6 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 13.5 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 1509.6 тэрбум төгрөг, нийт 7457.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч нийгмийн халамжийн тэтгэвэрт 1472 иргэнд 1213.0 тэрбум төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 2124 иргэнд 770.5 сая төгрөгийг зарцууллаа.

Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 1718 иргэнд 516.0 сая төгрөг, ахмад настаны нийгмийн халамжийн үйлчилгээнд 6537 иргэнд 370.4 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 475 иргэнд 115.4 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 1592 иргэнд 188.2 сая төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 5368 иргэнд 504.5 сая төгрөг, алдар цолтон ахмад настануудын тэтгэмжид 37 иргэнд 30.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Алдарт эхийн тэтгэмжид 10098 иргэнд 1332.8 тэрбум төгрөг, насны хишгийн зардалд 5388 иргэнд 581.6 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 6609 иргэнд 1434.7 сая төгрөг, өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 270 иргэнд 85.2 мянган төгрөг, банкны шимтгэлд 3.5 сая төгрөг нийт давхардсан тоогоор 41665 иргэнд 7146.3 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олголоо.

Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийх, өрхийн нөхцөл байдалтай танилцаж өрхийн гишүүдийн идэвх, оролцоо, эрэлт хэрэгцээнд тулгуурлан цаашид өрхүүдтэй хамтарч, эргэх холбоотой ажиллах зорилгоор Арвайхээр сумаас тус хөтөлбөрт хамрагдсан нийт 145 өрхөөс 90 өрх буюу 62%-д нөхцөл байдлын судалгаа авч ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 1 удаагийн хуралдаан зохион байгууллаа. Хурлаар нийт 4 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, 2 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 2 хүүхдэд байнгын асаргаа шинээр тогтоож, 1 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамруулсан байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАР

Монгол Улсын спортын мастер, боловсролын тэргүүний ажилтан, биеийн тамир спортын ажилтан, тэргүүлэх багш М.Батбаярын нэрэмжит волейболын тэмцээн 05 дугаар сарын 24-25 нд Арвайхээр суманд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд эрэгтэй 12, эмэгтэй 12 багийн нийт 168 тамирчид оролцлоо.

Хүүхдийн спортын VI их наадмын сонгох төрөлд орсон киркетын спортыг сурталчлан таниулах зорилгоор 05 дугаар сарын 22-23-нд Спортын ордонд зохион

байгууллаа. Тус сургалтанд биеийн тамирын 9 багш, өсвөрийн 22 хүүхэд хамрагдаж анхны шатны мэдлэгтэй боллоо.

Аймгийн Төгрөг сумын уугуул Хүндэт харваач, аймгийн гоц мэргэн Д.Сэмжаандонжид агсны нэрэмжит, Спортын мастер, аймгийн мэргэн М.Чойгийдавгад хүндэтгэл үзүүлэх аймгийн нээлтийн харваанд насанд хүрэгчидийн 34, өсвөр үеийн 25 нийт 59 харваач оролцсон.

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын уугуул Монгол Улсын Байт харвааны анхны гавьяат тамирчин, Үндэсний харвааны аймгийн дархан мэргэн Галсангийн Бямба агсны нэрэмжит, Үндэсний харвааны нэрт зүтгэлтэн Чимэдийн Лхагвад хүндэтгэл үзүүлэх аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Зүүнбаян-Улаан суманд зохион байгууллаа. Тэмцээн насанд хүрэгчдийн төрөлд хана, хасаа, нийлбэр, баг, өсвөр үеийн төрөлд нийлбэр, баг гэсэн 6 төрлөөр явагдаж, 44 насанд хүрэгч, 36 өсвөрийн харваач оролцлоо.

“Од” клубын нэрэмжит төвийн бүсийн “Гал унтраах техникийн олон төрөлт тэмцээн” 2019 оны 06 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд зохион байгуулагдаж 8 багийн 75 тамирчин оролцлоо. Тус тэмцээний 4 төрөлтийн нийлбэр дүнгээр Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 16 дугаар анги тэргүүн байр, Төв аймгийн 24 дүгээр анги дэд байр, Дундговь аймгийн 25 дугаар ангийн баг тамирчид гутгаар байранд тус тус шалгарлаа.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

2018, 2019 онд хамт олон, салбартаа манлайлсан шилдэг тэргүүний 3 анги хамт олныг "Цагаан залаа" зусланд амруулах ажлыг зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр салбар нэгжүүдийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны явцтай танилцаж, мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх, зөвлөн туслах чиглэлээр 15 суманд хүрч ажиллалаа.

Арвайхээр сумын 2 иргэнд гэр бүл цуцлалт, хүүхдийн асрамж тогтоолгож, тэтгэлэг гаргуулах талаарх хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Өвөрхангай аймагт төрийн албаны шинэчлэлийн талаарх нутгийн захиргааны байгууллагын дарга, ажилтан албан хаагч нарт зориулсан сургалтанд тус газрын төрийн захиргааны 6 албан хаагч хамрагдсан. Мөн хүүхэд, өсвөр үеийг ивээх сангаас Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Хүүхдийн сэтгэл зүйн онцлог, зан төлөв” сургалтанд тус газрын сэтгэлзүйч хамрагдаж чадавхжилаа.

Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан сумдад зохион байгуулагдсан зүүн болон баруун бүсийн хурдан морины уралдаанд уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалан ажиллаж, 120 хүүхдийн мэдээллийг цахим хурууны хээн бүртгэлд оруулсан.

Үндэсний статистикийн хорооны даргын баталсан залуучуудын асуудлаарх 129 шалгуур үзүүлэлтээр сумдаас анхан шатны мэдээллийг авч, нэгтгэн дүгнэж ажиллаж байна.

Арвайхээр сумын 3 дугаар багийн “...насанд хүрээгүй эмэгтэй хүүхэд алга болсон...” гэх мэдээллийн дагуу тус багийн хамтарсан багийн гишүүд, газрын сэтгэл зүйчийн хамт холбогдох 2 айлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, охиныг гэр бүлд нь эргэн нэгтгэж, шаардлагатай зөвлөгөө мэдээллээр ханган, цаашид хяналт тавин ажиллах үүргийг хамтарсан багт өгсөн.

Тус газрын зөвлөгөө өгөх өрөөгөөр дамжуулан 9 иргэнд сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгч, 2 гэр бүлийг гэр бүлд нь эргэн нэгтгэсэн. Мөн

Арвайхээр сумын 3-р багийн архины хамааралтай 2 өрхийн амьдралын нөхцөл байдалтай танилцан, үнэлгээ хийж ажилласан.

Гэр бүлийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд 15 суманд зөвлөн туслах чиглэлээр ажиллах хугацаанд тус хөтөлбөрт хамрагдсан өрх бүрт нөхцөл байдлын үнэлгээ хийж, өрхийн төлөвлөгөөг боловсруулж, 97 гэр бүлд хүрч ажилласан.

“Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан сургууль, цэцэрлэгт хамрагддаггүй байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхдийн гэрт очиж, бэлэг гардуулж, сэтгэлийн дэм өгөн тэдний өмнө тулгамдсан асуудлуудыг сонсон, холбогдох байгууллагуудад уламжилсан. Мөн зорилтот өрхийн 20 хүүхдийг хүүхдийн баярын үйл ажиллагаанд оролцуулж, бэлэг гардууллаа. Мөн өдрөөр тусгай хэрэгцээт хүүхэдтэй эцэг эхчүүдийн “Уулзалт-өдөрлөг”-ийн арга хэмжээг зохион байгуулсан. Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “ХҮҮХЭД БҮХЭН ЖАРГАЛТАЙ БАЙГ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж Хүүхдийн баярын арга хэмжээний нээлтийг Аюуш баатрын талбайд зохион байгуулсан. Баярын үйл ажиллагаанд Арвайхээр сумын ЕБ-ын 4-р сургуулийн авьяаслаг хүүхэд багачууд оролцож, спортын уралдаан тэмцээнүүд зохион байгуулагдлаа. Спортын арга хэмжээнд 600 орчим хүүхэд багачуудыг хамрагдлаа.

“Зөв тусгал” аяныг Аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Тус аяны хүрээнд 400 орчим залуучууд нэгдлээ. Мөн өдөр Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Аймгийн Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөл, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн төлөөлөлүүдтэй “Эртэч Монгол” өглөөний цайн уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад 170 гаруй хүүхэд, залуучуудын төлөөлөл оролцлоо.

Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний дуу хоолойг олон нийтэд хүргэх зорилгоор Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь МАН-н бүлгийн дарга Д.Тогтохсүрэнгийн ивээл дор зохион байгуулагдсан “Нар дагуулсан залуу нас” залуучуудын чуулга уулзалтыг 2019 оны 06-р сарын 21-с 2019 оны 06-р сарын 23-ны өдрүүдэд “Цагаан залаа” хүүхийн зусланд зохион байгууллаа. Тус уулзалтад аймгийн 13 баг болон Тарагт сумын залуучуудын төлөөлөл 700 гаруй залуучууд хамрагдаж өөрсдийн дуу хоолойгоо хүргэлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2019 оны 06-р сарын 06-с 2019 оны 06-р сарын 10 хүртэлх хугацаанд 21 аймаг 9 дүүргийн дунд зохион байгуулсан “Конвенц-30” арга хэмжээнд оролцлоо.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам хамтран “Сум хөгжүүлэх сан”-гийн өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэн цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, сангийн үр өгөөжийг дээшлүүлэх, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилготой улсын үзлэгийг зохион байгууллаа. Улсын үзлэгийн дүнгээр 2011-2018 онуудад нийт 3207 төсөлд 15.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож 4009 шинэ ажлын байр бий болж, 2328 ажлын байр хадгалагдаж эргэн төлөлт 86.4 хувьтай байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас манай аймагт 1.0 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр хуваарилагдсан. Үүний дагуу “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөр, Эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх хөтөлбөр болон аймгийн тэргүүлэх чиглэлд хамаарах 7.5 тэрбум төгрөгийн хүсэлттэй 85 төслийг хүлээн авч иж бүрдлийг шалган, программд шивэх ажил хийгдэж байна.

“Үндэсний уламжлалт болон орон нутгийн онцлог бүхий хоол, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих, таниулах сурталчлах” ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайтад байршуулахаар өөрийн аймгийн онцлог, дахин давтагдашгүй соёлыг шингээсэн, үндэсний уламжлалт аргаар боловсруулсан аймгийн нэрийн хоолнуудын жор, танилцуулгыг хүргүүллээ.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан дэлхийн 25 орны 900 гаруй тогооч оролцсон “Чингис хааны цом-2019” олон улсын мэргэжлийн тогоочдын үр чадварын тэмцээнд манай аймгаас 6 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож загас, тахиан махан хоолны төрлөөс 2 тогооч мөнгөн медаль, 1 тогооч хүрэл медаль, 3 тогооч тусгай байранд шалгарч мэргэжлийн түвшин, үр чадвараа дээшлүүлэн амжилттай оролцлоо.

Олон улсын хоршоологчдын өдрийг угтаж Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нэг сум-Нэг хоршоо” хөдөлгөөнийг өрнүүлэн загвар хоршоодыг бий болгох зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, Чадваржсан иргэд-Тогтворжсон амьжиргаа төсөлтэй хамтран “Зохистой хөдөлмөр эрхлэлт ба залуучуудын оролцоо” аймгийн залуу хоршоологчдын зөвлөгөөнийг зохион байгуулав.

Аймгийн хэмжээгээр энэ оны хавар 10907,3 га талбайд тариалалт хийж, үүнээс үр тариа 7136,6 га, улаан буудай 6860 га, бусад үр тариа 276,6 га, тосны ургамал 2155 га, малын тэжээл 976,5 га, төмс 391 га, хүнсний ногоо 232,1 га-д тус тус тариалж, улаан буудайн тариалалт 101 хувь, төмс 100 хувь, хүнсний ногоо 100 хувь, малын тэжээл 114 хувь, нийт тариалалт 119,9 хувийн биелэлттэй байна. Энэ оны тариалалтыг урд онтой харьцуулахад улаан буудайн үйлдвэрлэл 14.0 хувиар, төмс 5.0 хувиар, хүнсний ногоо 10.0 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Үр тарианы соёлолтын байдлыг тооцоход 99,5 хувьтай буюу нийт талбайн 27,1 хувь хангалттай сайн, 14,4 хувь нь сайн, 56,4 хувь нь дунд, 2,1 хувь нь муу соёолттой гэсэн дүгнэлттэй байна.

Япон улсын Хоккайдо мужийн Такикава хотын захиргаатай хамтран “Газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн агро бизнесийг хөгжүүлэх” төслийн хүрээнд 19 сумын 130 тариаланч бөөрөнхий сонгиныг үрслэгээр туршин тарих ажлыг хийж байна.

Монгол Улсад атар газар эзэмшиж газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний түүхт 60 жилийн ой тохиож буйтай холбогдуулан “Атар-60” ойн медалийн захиалгыг авч медалийг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна. Мөн аймгийн газар тариалангийн салбарын түүхийн дурсамж ном бүтээхээр төлөвлөж, төмс хүнсний ногоо эрхлэгчдийн дунд “Атар-60” болзолт уралдаан зарлаж болзол, удирдамж зөвлөмжийг сумдад хүргүүлэн ажиллаа.

“Алсыг харъя, Органикийг сонгоё” сарын ажлын хүрээнд хуурамч шошго бүхий бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэхээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тандалт судалгааны явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, дүнг нийтэд мэдээлэх, сурталчлах замаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилготой тандалт судалгааг 2019 он 05 дугаар сарын 21-29-ний өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Тандалт судалгаанд нийт худалдаа үйлчилгээний 49 аж ахуйн нэгж иргэнийг хамруулсан. Тандалт судалгаанд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний 60% нь баталгаажуулсан гэрчилгээгүй байна. Бүтээгдэхүүний шошгод “100% байгалийн гаралтай”, “цэвэр байгалийн гаралтай”, “экологийн цэвэр бүтээгдэхүүн” гэх мэт бичиглэлтэй, эрх бүхий байгууллагаас органик гэдгийг тогтоогоогүй, хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулаагүй, албан ёсоор хүлээн зөвшөөрч, дүгнэлт гаргаагүй, гэрчилгээгүй хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалсан

зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 9 албан шаардлага, 20 газарт сануулга, 6 объектод зөвлөмж хүргүүлж, хууль тогтоомж стандартыг сурталчлан ажиллалаа.

Мал үржлийн чиглэлээр

Малын генетик нөөцийн тухай хууль батлагдсантай холбогдуулан бүс нутгийн түвшинд малын удмын санг хамгаалах, үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мал үржүүлгийн ажилд дэвшилтэд технологийг нэвтрүүлэн малын ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд Баянгол сумын Баянгол омгийн 10000 хонь, Нарийнтээл сумын Тээлийн улаан хэвшлийн 10000 ямаа, Уянга сумын 5000 Сарлаг үхэрт үзлэг ангилалтын ажил явуулахаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай гэрээ байгуулав.

Гэрээний дагуу аймгийн Засаг даргын 319 дүгээр захирамж, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын А/09 дугаар тушаалаар Баянгол сумын "Баянгол омог"-ийн хонин сүргээс 170 хээлтүүлэгч, 4340 хээлтэгчийг, Уянга сумын Таац, Жаргалантын сарлагаас 2485 хээлтэгч, 15 хээлтүүлэгч, Нарийнтээл сумын Тээлийн улаан ямаан сүргээс нийт 429, 17 хээлтүүлэгч, 412 хээлтэгчийг үзлэг ангилалтад хамрууллаа. Мөн зохиомол хээлтүүлгээр гарсан 250 хурга, 132 ишгэнд хэмжилт, жинлэлт хийж ээмэгжүүлсэн.

Мал төлөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдолын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр сумдаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлого зохицуулалтын газар болон Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэн ажиллаж байна. 06 дугаар сарын 24-ний байдлаар нийт хээлтэгч малын 83.4 хувь буюу 1986.9 мянган мал төллөснөөс 58.9 мянган төл мал хорогдож гарсан төлийн 97.8 хувь буюу 1927.9 мянган төл бойжиж байна. Мөн нийт хээлтэгчийн 0.3 хувь нь буюу 7.8 мянган мал хээл хаясан. Цаг агаарын нөхцөл байдлын улмаас аймгийн хэмжээнд нийт малын 1.2 хувь буюу 65.8 мянган том мал хорогдсон дүн мэдээтэй байна.

Орон нутагт өсгөн үржүүлж буй цөм сүргийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх удмын санг хамгаалах, цаашид баталгаажсан үүлдэр, омгийн малаар батлуулах зорилгоор Гучин-Ус сумын Монголын хоолойн тэмээ, Нарийнтээл сумын Тээлийн улаан нутгийн шилмэл хэвшлийн ямааны аж ахуйн биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгааны арга зүйг боловсруулан Мал аж ахуйн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн их эрдэмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батуулсан.

Сумдын бэлчээр ашиглагчдын хэсгийг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах, малын гаралтай түүхий эдийн мөшгих тогтолцоог хөгжүүлэх зорилгоор "Ногоон Алт" Малын эрүүл мэндийн төслийн загвар сум болох Уянга, Бат-Өлзий суманд хамтарч хэрэгжүүлэхээр хариуцлагатай нүүдэлчин уриатай сургалтыг зохион байгуулав.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Сумын хилийн цэсийн тодруулалтын хээрийн хэмжилтээр Тарагт, Хайрхандулаан, Уянга сумдтай хил залгаа нутаг дэвсгэрт хээрийн хэмжилт, тодруулалтыг хийж, сумдын нутаг дэвсгэрт байрлал, өдрийн сүлжээний 3 ширхэг /BTC-1913, Төмөр пирамид, төвийн дугааргүй модон пирамид/ геодезийн цэг, тэмдэгтийг шинээр тогтоон солбицлын тодорхойлон бүртгэлжүүлсэн.

Богд сумын ерөнхий төлөвлөгөөнд туссан байршлын дагуу амины орон сууцны зориулалтаар 15 иргэнд эзэмшүүлэх газрын хил зааг, эргэлтийн цэгийг газарт буулгах хэмжилтийг хийсэн.

Хүн ам, орон сууцны улсын урьдчилсан тооллогын ажилд зориулан Арвайхээр сумын 13 багийн хаягийн зургийг тоон болон хэвэлмэл байдлаар гаргаж,

Арвайхээр сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөд туссан 175 айлын хаус хорооллын цахилгаан хангамжийн шугам сүлжээ, дэд станц, бохир усны шугам сүлжээний трасс, 57 иргэнд нэгж талбар болон байшингийн хил зааг, эргэлтийн цэгийг газарт буулгах хэмжилтийг хийж тэмдэгжүүлсэн.

Аймгийн хэмжээнд 06 сарын 01-ны байдлаар 1:1000, 100000-ны масштабтай байр зүйн тоон зургийн мэдээллийн санд 14 суманд шинээр байгуулагдсан болон өөрчлөлт орсон объектын шинэчлэлтийг зохион байгуулан ажиллаж мэдээллийн санд баяжилтыг хийлээ. Үүнд: Шинээр хашаа барьж хашаалсан 117 нэгж талбар бүхий газар, 158 ш байшин, барилга, 96 нэгж талбарын хил, заагийн газарт бэхэлсэн эргэлтийн цэгийг актаар хүлээлгэн өгсөн.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/371 дүгээр захирамжаар 27 иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн газрын хэмжээнд өөрчлөлт оруулан мэдээллийн нэгдсэн санд оруулсан, А/372 дугаар захирамжаар 13 өрхийн нэр бүхий 42 иргэний өмчлөх эрхийг шилжүүлсэн, А/373 дугаар захирамжаар “Монгол Улсын ирэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлөх хүсэлт гаргасан 145 иргэнд 9.16 га газрыг тус тус өмчлүүлсэн.

Богд сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Баян-Өндөр сумын Спорт заалны барилга, “Номин реалтор” ХХК-ийн агуулах худалдааны төвийн барилга, байгууламжид дотоод хяналтыг хийж үүрэг даалгавар өгөн ашиглалтад оруулах комиссын мэдэгдлийг хүргүүлээд байна.

Арвайхээр сумын 928 хүүхдийн мэргэд лабортори сургууль, Цагдаагийн газрын конторын барилга, МХГазрын конторын барилга, 50 ортой хүүхдийн эмнэлэг, Усан спортын цогцолбор, 320 хүүхдийн сургууль, Хархорин сумын 320 хүүхдийн сургууль, 75 хүүхдийн цэцэрлэг, Хужирт сумын 75 хүүхдийн цэцэрлэг, Баянгол сумын Соёлын төвийн барилга, Төгрөг сумын Спорт заал, Цэцэрлэгийн өргөтгөл, Гучин Ус сумын Соёлын төв, Богд сумын 320 хүүхдийн сургууль, Баян-Өндөр сумын Спорт заал, Бүрд сумын Соёлын төв, Уянга сумын 100 хүүхдийн дотуур байр, Баруунбаян-Улаан сумын 100 хүүхдийн дотуур байр, Тарагт сумын Спорт заалны барилгуудад үе шатны явцын хяналтыг 1-3 удаа хийж үүрэг даалгавар өгөв.

Арвайхээр суманд шинээр баригдах 150 хүүхдийн цэцэрлэгийн ажлын тоо хэмжээг гарган Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, Аймгийн Засаг даргын захирамж болон, Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг үндэслэн 7 барилга угсралт, 18 их засварын ажлын гэрээг холбогдох барилга угсралтын компаниудтай байгуулж, Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах 7 барилга угсралтын ажилд холбогдох бичиг баримтыг хянан бүрдүүлүүлж ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн хүрээнд “Ногоон паспорт–Ногоон төгөл” модлог ургамлын цуглуулга бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын нээлтийг зохион байгуулж, Ногоон паспорт аянд хамрагдсан Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургуулиудын “Эко бүлгэм”-ийн 130 гаруй сурагчид оролцлоо.

БОАЖЯамны дэмжлэгээр байгуулагдаж байгаа Цэцэрлэгт хүрээлэнд улиас, хайлаас, шар хуайсыг ойн зурвас хэлбэрээр тариалснаас гадна агч, гүйлс, долоогоно, голт бор, монос, тэхийн шээг, далан хальс, интоор, өрөл гэх мэт 14 нэр төрлийн 500 ширхэг гоёл чимэглэл, жимс жимсгэнийн мод бут суулгасан. БОАЖЯамнаас цэцэрлэгт хүрээлэн байгуулахад шаардлагатай усалгааны систем, 10 тн багтаамжтай усны сав, тарьц суулгац, ажиллах хүчний зардал, хамгаалалтын

хашааны материал, сүүдрэвч, хувин, хүрз гэх мэт багаж хэрэгсэл олгож дэмжлэг туслалцаа үзүүлээ.

Арвайхээр хотын ногоон байгууламжийн үйл ажиллагааг дагнан хариуцдаг ойн мэргэжлийн байгууллага “Арвайхээр–Цэцэрлэгжилт” ОНӨААТҮҮГазарт хариуцуулж БОАЖЯамтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж хашаа барих, услалтын систем угсрах, мод бут тарих ажлыг бүрэн хийж дуусгаад байна.

Хужирт рашааныг түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа рашаан ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагуудад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулахад анхаарах асуудал, рашаан ашиглуулах дүгнэлт гаргуулах хууль эрх зүйн үндэслэл сэдвээр сургалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

“Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, устгах” журмыг боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулсан. Энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг 4500 төгрөг, нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх зардлын нэгж тарифыг 3 төгрөгөөр тооцоолж батлуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулагдсан аялал жуулчлалын үйлчилгээний салбарын ажилтнуудыг чадавхжуулах сургалт Арвайхээр суманд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг жуулчны бааз 5, зочид буудал 4, ресторан 2 нийт 112 иргэн хамрагдлаа.

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР

Мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос ирсэн мэргэжилтний хамтаар 2 ажлын хэсэг шүлхий болон бог малын мялзан өвчний ийлдэс судлалын тандалт шинжилгээний дээж цуглуулахаар 6 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн Бат-Өлзий, Уянга, Хайрхандулаан, Богд суманд ажиллав.

Шаардлагатай оношлуур, урвалжийг найруулж бэлтгэн шинжилгээнд ашиглаж байгаа ба энэ сард нян судлалын лабораторид 9 сумын 259 дээжинд шинжилгээ хийхэд Гучин-Ус тэмээ 1, Уянга нохой 1 галзуу өвчнөөр, Баянгол 3 хонь, Тарагт 34 хонь, Арвайхээр 10 хонь, Төгрөг 4 хонь, Өлзийт 1 хонь, Хайрхандулаан 1 хонь ДХХ өвчнөөр, Тарагт 5 хонь, Баянгол 1 хонь, Баян-Өндөр 2 хонь энтеробактериоз өвчнөөр өвчилсөн болох нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан. Хариуг сумын МЭТасаг, МЭҮНэгжийн эмч нарт хүргүүлж, зааврын дагуу арга хэмжээ авлаа.

Ийлдэс судлалын лабораторид Баянгол сумын 300 хуц, Тарагт сумын 3 хуц, 1 эм хонь, Арвайхээр сумын 6 хуц, 10 ухны ийлдсийн дээжинд бруцеллэз илрүүлэх шинжилгээ хийхэд бруцеллэзын эсрэгбием илрээгүй. Боом өвчний тандалт шинжилгээнд Арвайхээр сумын “Арвай” түүхий эдийн төвөөс 3 ямааны арьс, 2 хонины нэхийний дээж авч асколийн урвалаар шинжлэхэд боомын эсрэгтөрөгч илрээгүй.

Вакцинжуулалтын орон нутагт зохион байгуулж Шөвөг яр-100%, галзуу 80%, дуут хавдар 90%, Цусан халдварт 80%, Дхх 80 % боом- 60%, ДХХ-Энтеробактериоз- 90% -ыг малын эмч нарт тараагдаад байна.

ХХААХҮЯам, Хядат улсын Худалдааны яамтай хамтран БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд 2019 оны 5 дугаар сарын 21-нээс 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт газрын Зооноз, халдварт өвчин тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн онолын болон практикийн мэдлэг, мэргэшлийн үр чадварыг дээшлүүлэх, тэнхмийн сургалт нийт 23 удаагийн 149 цаг, газар дээрх сургалт 11 удаагийн 70 цаг, үзэж танилцах 8 бүтэн өдрийн аялалд оролцсон. Мөн 2019 оны 5

дугаар сарын 28-ны өдрөөс 6 дугаар сарын 21-ны хүртэлх хугацаанд Итали улсын Cuneo хотын Clinica veterinaria dottori Mattalia мал эмнэлэгт туршлага судлах аялалд Шимэгч судлалын шинжээч их эмч, Хужирт суман дахь Мал эмнэлгийн тасгийн дарга нар оролцсон.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны “Хөрөнгө акталж данснаас хасах тухай” 44 дүгээр тогтоол, Баянгол сумын Соёлын төвийн барилга, Хайрхандулаан сумын соёлын төвийн барилга, “Хөрөнгө акталж данснаас хасах тухай” 49 дүгээр тогтоол Цагдаагийн газрын хөрөнгөд бүртгэлтэй зүүн постны барилгыг актлав.

Арвайхээр суманд Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, шинэчлэл, Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмж, Хархорин, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга сумын сургуулиудад Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн салбарын их засвар, тоног төхөөрөмж, Төрийн байгууллагуудын засвар, тоног төхөөрөмж, Хархорин, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга сумын соёлын төвд их засвар, тоног төхөөрөмж дахин зарлав.

Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ISO-9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил, Хаан банкнаас Онги төв хүртэлх авто замын ажил, Арвайхээр суманд шинээр баригдах түрээсийн орон сууцны барилга угсралтын ажил, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, тоног төхөөрөмж, Баян-Өндөр, Өлзийт, Төгрөг сумын Багийн төвийн барилга, Арвайхээр сумын халаалтын зуухнуудад шүүлтүүр тавих, Жирэмснээс хамгаалах эм, хэрэгсэл зэрэг 14 тендер нээлттэй зарласны 9 тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, хадгалалтын байдалд хийх төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн дагуу Арвайхээр сумын Зоонозын өвчин судлалын төв, Мал эмнэлгийн газар, Цуврайн гол ЗБН-д хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлагыг дээрх 3 байгууллагад хүргүүлж биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Уянга суманд үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалт хийж, захирал, хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтнуудад заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Арвайхээр суманд оёдлын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “ТОП ЗҮҮ” ХХК-д төлөвлөгөөт шалгалт хийж, холбогдох ажилтнуудад заавар зөвлөгөө өгч, илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын удирдамжийн дагуу Цагаанзалаа зуслангийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар хоол үйлдвэрлэлийн технологийн картгүй, түүхий эд бүтээгдэхүүний дагалдах шинжилгээний бичиггүй зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Баянгол сумын төвийн орон нутгийн чанартай Онгийн голын модон гүүрийн арчлалт, урсгал засвар ашиглалтын үйл явцад шалгалтыг хийлээ. Тус гүүр нь 2015

онд ашиглалтад орсноос хойш орон нутгийн зүгээс арчлалт урсгал засварын ажлууд хийгдээгүй байдалтай байгаа нь гүүрийн бүтээцэд эвдрэл үүсэх нөхцөл бүрдэж, 53,3 %-тай их эрсдэлтэй үнэлэгдэж, цаашид хэрэгжүүлэх ажил үйлчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай” 5 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүллээ.

СУМДЫН МЭДЭЭЛЭЛ

Арвайхээр суманд 2019 оны хагас жилийн дүнгээр эрүүл мэндийн үзлэгт давхардсан тоогоор 31125 иргэн, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 11169 иргэнийг хамруулсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 560 иргэн буюу 5.2 хувиар өссөн байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүд Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Сүрьеэгийн тасагтай хамтран эрсдэлт бүлгийн иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Үүнд: Уян сэтгэл 281 иргэнээс 270 буюу 96.4 хувь, Түшигдөлгөөн 284 иргэнээс 206 буюу 72.5 хувь, Нарны дөш 287 иргэнээс 206 буюу 90.5 хувь сумын дүнгээр 852 иргэн хамрагдахаас 736 буюу 86.3 хувьтай хамрагдлаа.

Тарагт суманд “Жайка” ОУБ-ын санхүүжилтэр “Өвсний үндэс” төслийн хүрээнд Хүнсний боловсруулах цех, бэлэн бүтээгдэхүүн худалдаалах төвтэй боллоо. Энэхүү худалдаалах төвтэй болсноор сумын иргэд бүлэг болж, өөрсдөө үйлдвэрлэгч болон өрхийн орлогоо нэмэгдүүлэх бүрэн боломжтой болж байна.

Бүрд суманд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих ажлын хүрээнд төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг, зээлд хамрагдсан иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав.